



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 593

Улаанбаатар хот

Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр  
суралцуулах, суралцах хугацааг сунгах

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Лизунова Ленаг АНУ-ын Жонсон Уэйлсийн их сургуулийн магистрантурт Бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн, Монгол банкны захиалгаар Эрдэнэцогтын Соёлмааг Люксенбургийн Вант Улсын Люксенбургийн их сургуулийн магистрантурт Санхүүгийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар тус тус суралцуулсугай.
2. АНУ-ын Нортвестерн Политехникийн их сургуулийн магистр Бүрэнтогтохын Наранжаргал, АНУ-ын Миссури мужийн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн магистр Баярмагнайн Баясгалан, АНУ-ын Дикинсон их сургуулийн оюутан Бямбадоржийн Цэнгүүн нарын Сургалтын төрийн сангийн зээлээр суралцах хугацааг тус тус нэг жилээр сунгасугай.
3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР